

# МОНГОЛЫН ОРОН НУТГИЙН МЭДЭЭ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

## Амьд Бурханд итгэх итгэл

**Ахлагч Стэнли Вон**

Хятадын удирдлагын нэгжийн захирал

Амьд Бурханд итгэх итгэл нь итгэл, дуулгавартай байдал мөн зөв шударга үйлсээр дамжин ирдэг Бурханы бэлэг юм. Зөвхөн ямар нэг зүйлд итгэлтэй байх нь хангалтгүй бөгөөд итгэл нь бидний Тэнгэрлэг Эцэг болон Түүний Хүү, Есүс Христ дээр төвлөрөх ёстой. Ахлагч Даллин Х.Өүкс: “Сайн мэдээний анхдагч зарчим бол итгэл биш, харин энэ нь Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл юм. Итгэл нь дангаараа оршдоггүй бөгөөд ямар нэг бодит зүйлийг шаарддаг. Итгэл нь мөн ямар нэг зүйлд эсвэл хэн нэгэн хүн дээр суурилах ёстой. Энэ ч утгаараа итгэл нь хайртай адил юм. Хайрлах ямар нэг зүйл байхгүй бол хайр оршиж чадахгүй”<sup>1</sup> хэмээн тайлбарлажээ.

Ахлагч Рассэлл М.Нэлсон “Хүүхдүүдээсээ эхэл. Эцэг, эхчүүд та нарт үр хүүхдүүдийнхээ итгэлийг хүчирхэгжүүлэх гол үүрэг хариуцлага оногддог. Та нарт сорилт бэрхшээл тохиолдсон үед ч гэсэн итгэлээ хүүхдүүдэд харуул. Та бүхэн итгэлээ бидний хайрт Тэнгэрлэг Эцэгт болон Түүний Хайрт Хүү, Их Эзэн Есүс Христ дээр төвлөрүүлэгтүн. Энэхүү итгэлийг гүн гүнзгий итгэл үнэмшилтэйгээр заа. Хайртай хүү эсвэл охиндоо тэд бол Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн Түүний хүүхэд юм гэдгийг эрхэм ариун зорилго, чадавхтайгаар заа. Хүүхэд бүрд даван туулах ёстой бэрхшээл, хөгжүүлэх шаардлагатай итгэл байдаг”<sup>2</sup> гэж заасан билээ.

Дэниэл Рэйд Хэлстэн хүүхэд байхдаа сүмийн бүрэн цагийн номлолд үйлчлэхээр



**Ахлагч  
Стэнли  
Вон**

аль эрт шийдсэн байжээ. Тэр Хятадад бүрэн цагийн номлогчоор үйлчлэх хүсэлтэй байгаагаа хэлэх болгонд бусад хүмүүс түүнийг шоолон инээлддэг байв. Тэр номлолын насанд хүрч, номлолын өргөдлөө явуулах үедээ энэ мөрөөдлөө мартаагүй байсан юм. Номлолын дуудлага ирсэн ч Хятадад биш байлаа! Хэдийгээр олон хүмүүс түүнийг шоолсон ч энэ нь амьд Бурханд итгэх түүний итгэлд нөлөөлөөгүй юм. Учир нь түүний гэрчлэл ямар нэг зүйлийн үр дүнд суурилагаагүй байсан юм. Тэрээр номлолын дуудлагыг хүлээн зөвшөөрч, Их Эзэний мутар дахь үр ашигтай

зэмсэг байхыг эрмэлздэг байв. Номлолынх нь сүүлийн хэдэн сард би түүний номлолын ерөнхийлөгчөөр дуудагдсан бөгөөд 1997 оны 7-р сарын 1-нд британичууд Хонг Конгийн Хятадад буцааж өгөхөд түүний үйлчилж байсан номлолын нэр Хятадын Хонг Конг номлол болон өөрчлөгдсөн юм.

Ахлагч Норимичи Наканиши Японы Токиогоос ирсэн байлаа. Тэр бол намайг номлолын ерөнхийлөгч байх үед Хятадын Хонг Конг номлолд үйлчилсэн япон номлогч байсан юм. Би түүнтэй хийсэн анхны санваарын хувийн ярилцлагаа хэзээ ч мартаггүй. Тэр хятадаар ч, англиар ч ярьдаггүй байсан учраас эхэндээ бид хоёр огт ойлголцож чадаггүй байлаа. Нэг удаа бид хоёр чимээгүй сууж байгаад намайг түүн рүү харахад тэр надруу инээмсэглэж билээ. Тэр өдөр бид хоёр япон хэлний “канжи” цагаан толгой нь хятад ханзтай бараг адилхан болохыг олж мэдсэн бөгөөд ярилцлагаа дохио зангаа ба үзэг, цаасны тусламжтайгаар өндөрлөсөн юм. Өөрт нь хэл, соёлын бэрхшээл тулгарсан ч ахлагч Наканишигийн итгэл зөвхөн өөрийн хүч чадал дээр бус харин амьд Бурхан дээр төвлөрсөн байлаа. Хэдэн сарын дотор тэрээр хятад хэлээр сайн мэдээг чөлөөтэй хуваалцдаг болсон юм. Америк номлогчидтой цуг амьдарснаар түүний англи хэл ч сайжирч эхэлсэн. Хэлний бэрхшээл нь итгэлтэйгээр үйлчлэх түүний хүсэлд саад болж чадаагүй юм. Түүнтэй хийсэн сүүлчийн ярилцлага дээр тэр хятадаар чөлөөтэй ярьж байсан төдийгүй англиар ч бас сайн ойлгож байлаа. Би түүнд Японд буцаж очоод япон хэлээ дахин сурах хэрэгтэй юм байна даа хэмээн хошигнон хэлж билээ!

Бурхан нүүр тал хардаггүй гэдэгт би үнэхээр итгэдэг. Аль орноос ирснээс нь үл хамааран бүх номлогчид үүргээ биелүүлэхийн тулд хэлний бэлгийг хүлээн авах эрхтэй байдаг. Тэд Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлтэй байж. Бүх зүрх сэтгэл, хүч чадал, оюун ухаанаараа ажиллах үед Ариун Сүнс тэдэнд хэлний болон бусад бэрхшээлүүдийг шийдвэрлэхэд мөн сайн мэдээг дэлхийн өнцөг булан бүрд дэлгэрүүлэхэд туслах болно.

Үнэн итгэл нь итгэл, үйдэл хоёроос бүтдэг. Есүс “Намайг Эзэн минь, Эзэн минь гэсэн болгон тэнгэрийн хаанчлалд орохгүй. Харин тэнгэрт байгаа Миний Эцэгийн хүслийг биелүүдэг хүн орно”<sup>3</sup> гэж хэлсэн байдаг. Харамсалтай нь зарим хүмүүс зовлон шаналын гүнд очих хүртлээ Бурханыг санадаггүй. Энэ цаг үеийн хамгийн эмгэнэлтэй зүйлүүдийн нэг бол үнэний бодит байдлыг хардаггүй хүмүүний харалган байдал юм. Амьдрал тайван, хэвийн байх үед Бурханы хайр ба нигүүлсийг мартаж хэчнээн хялбар байдаг билээ! Тийм боловч олон хүний мэдэх Хуучин Гэрээн дэх Иовын түүх нь хүмүүс өөрт нь үнэнч, итгэлтэй байгаа үед Бурхан тэднийг хэзээ ч найдваргүй цөхрөл дунд орхидоггүйг бидэнд илчилсэн юм. Сүмд байгаа итгэлтэй гэр бүлүүд агуу бэрхшээлүүдийг хэрхэн даван туулж байгааг харах нь бидний гэрчлэлийг үргэлж хүчирхэгжүүлдэг.

Итгэл гэдэг нь Их Эзэн Есүс Христэд итгэхийг хэлдэг. Ахлагч Даллин Х.Өүкс хүнд өвчнөөр нас барсан нэгэн өсвөр насны охины оршуулган дээр үеэлийнхээ хэлсэн үгээс энэ итгэлийг мэдэрчээ. Тэрээр эхэндээ үеэлийнхээ хэлсэн үгсийг сонсоод ихэд цочирдсон ч

удалгүй сүнсээр зааварлагдсан байна. Түүний үеэл, “Энэ охины үхэл нь Их Эзэний хүсэл байсныг би мэднэ. Охин сайн эмчилгээ хийлгэсэн байна. Түүнд санваарын адислалууд өгөгджээ. Түүний нэрийг ариун сүмийн залбиралд оруулсан байсан бөгөөд хэдэн зуун хүн түүний эрүүл мэндийн төлөө залбирсан юм. Хэрэв энэ цаг мөчид Их Эзэн түүнийг буцааж аваагүй байлаа ч түүнийг эдгээж чадах хангалттай итгэл энэ гэр бүлд байгаа гэдгийг би мэднэ” хэмээн хэлжээ. Ахлагч Өүкс хорт хавдраар нас барсан бас нэгэн охины аавын үгсээс үүнтэй адил итгэлийг мэдэрсэн юм. Тэр аав “Есүс Христэд итгэх манай гэр бүлийн итгэл аливаа зүйлийн үр дүнгээс хамааралтай байдаггүй”<sup>4</sup> гэж хэлжээ.

Өнөөдөр бид Фараоны боолууд биш бөгөөд Мосегийн үед байсан устгагч тэнгэр элчүүд ууган хөвгүүдийг маань хөнөөнө гэж айх хэрэггүй юм. Сатаны заль мэх, хүч их болсон өнөө үед бидэнд тулгарч буй сорилт бэрхшээлүүд тэс өөр бөгөөд илүү хүнд юм. Бид үймээн самуунтай цаг үед амьдарч байна. Бид дайнууд болоод дайны сураг чимээ, өлсгөлөн, тахал, газар хөдлөлт, цунами мөн өвчин эмгэг, завхрал түүнчлэн эдийн засгийн хямрал, гэр бүл сөнөх аюул болон өсөн нэмэгдсээр буй гэр бүл салалтын тухай сонсдог. Бидэнд санаа зовох шалтгаан маш их байна. Гэвч бид итгэлээ айдсаар солих хэрэггүй юм. Бид амьд Бурханд итгэх итгэлээ хөгжүүлэх замаар л айдастайгаа тэмцэж чадна!

Зөв шударга байдал ба сайн үйлс нь агуу итгэлийг бий болгодог бол нүгэл ба ёс бус байдал нь итгэлийг үгүй болгодог. Ерөнхийлөгч Бригам Янг “Хэрэв хожмын үеийн гэгээнтнүүд

онцгой боломжууддаа тохирохоор амьдарч, Есүс Христийн нэрэнд итгэх итгэлтэй байж, өдөр бүр Ариун Сүнстэй хамт амьдарвал тэднийг хүсэх үед энэ дэлхий дээр өгөгдөхгүй зүйл гэж байхгүй байх болно. Их Эзэн өөрийн хүмүүст өгөөмрөөр хандаж, баялгууд болон хүндлэл, алдар суу, хүчийг мөн бошиглогчид ба төлөөлөгчдийн амласан бүх л зүйлийг тэдэнд өгөхөөр хүлээж байдаг”<sup>5</sup> хэмээн хэлсэн байдаг. Мөн тэрээр: “Энэ сүмд харьяалагддаг хүн бүхэн итгэлтэй байх ёстой. Тэд Ариун Сүнсний гэрэл гэгээг хүлээн авахын тулд өөрсдөдөө найдахаас иүүтэйгээр Их Эзэн Есүс Христэд итгэх итгэлээ идэвхтэйгээр ашиглах ёстой. Тэд үүнийг үл тоомсорловол дэлхийн сүнс тэднийг эзэмдэж, тэд хүйтэн хөндий бөгөөд үр жимсгүй болон доройтсоор харанхуйг болон сүнсний үхлийг амсах болно”<sup>6</sup> гэж хэлжээ.

Бид амьд Бурханд итгэх итгэлтэй байгаа үед айх хэрэггүй хэмээн онцгойлон гэрчлэхийг би хүсч байна! Би Бурхан амьд гэдгийг мэднэ. Есүс Христ хэмээх энэ нэр нь бид бүгдэд аврал авчрах нэр юм. Тэр бол бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдрахаар буцаж очих цорын ганц зам мөн. Есүс Христийн нэрээр, амен. ■

#### ЭШЛЭЛ

1. Далин Х. Өүкс, Есүс Христэд итгэх итгэл, Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий хуралдаан дээр, 1994 оны 4-р сар.
2. Рассэлл М. Нэлсон, “Ирээдүйг итгэлээр угт”, *Ensign*, 2011 оны 5-р сар, 34.
3. Матай 7:21.
4. Ахлагч Далин Х. Өүкс, “Өвчтөнийг эдгээх нь” *Ensign*, 2010 оны 5-р сар, 50.
5. *Discourses of Brigham Young*, Жон А. Видцөү (1954), 156.
6. *Teachings of Presidents of the Church: Brigham Young*, (1997), 54 мөн *Deseret News Weekly*, 1855 оны 4-р сарын 25, 2-ыг үзнэ үү.

## Орон нутгийн мэдээний редактор Н.Пүрэвсүрэн

Монголд сүм байгуулагдсанаас хойш нийгмийн олон салбарт төрөл бүрийн сайн дурын үйлчлэлийг сүмийн гишүүд маань хийсээр ирсэн билээ. Тэд банк санхүү болон эрүүл мэндийн салбарт олон бодит үйлчлэлийг хийсэн юм. Нүд, шүдний эмч нар ирж нярайн эндэгдэл мөн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд үүний нэг жишээ нь доктор Рэй Прайс эмчийн үйлчлэл юм. Тэрээр Монголын анагаах ухааны салбарт дурангийн хагалгааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор сүүлийн таван жилийн турш дотор, гэмтэл, нуруу нугас, нүдний мэргэжлийн эмч нарыг явуулж сургалт зохион байгуулахын зэрэгцээ Америкийн Зүрх Судасны Нийгэмлэгийн эрүүл ахуйн курс сургалтыг монгол хэлээр орчуулан танилцуулсан байна. Прайс эмч Свонсон Сангаас хандивласан олон сая долларын үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг зуучлан авчирч Монголын Баруун, Зүүн, Хойт болон Төвийн бүсийн эрүүл мэндийн



*Доктор Прайс Монголын Засгийн Газрын гишүүнтэй уулзаж байгаа нь*

*Доктор Прайс шагнал хүртэж байгаа нь*

төв дээр сургалт зохион байгуулж “Үзүүлэх хагалгаа”-г амжилттай хийсэн билээ. Прайс эмчийн энэхүү гайхалтай энэрлийн ажилд түүний гэр бүл болон бусад сайн дурын эмч нар дэмжин оролцдог аж.

Монголд анх энэ ажлыг хийхээр зорих үед олон хүн дэмжээгүй байна. Италийн мэс засалчид дурангийн хагалгааг монголд хөгжүүлэх нөхцөл бүрдээгүй хэмээн бичиж байсан бол Шведийн мэс засалчид хоёр жилийн турш түүнийг дэмжээгүй билээ. Гэвч Монголд дурангийн хагалгааг хөгжүүлэхийн төлөө есөн жилийн турш зүтгэн ажиллаж буй Анагаах Ухааны Их Сургуулийн мэс заслын тасгийн эрхлэгч Сэргэлэн эмч Ганболд, Энх-Амгалан, Бат-Эрдэнэ болон доктор Холланд, Солт Лэйк хотын Хүмүүнлэгийн Тусламжийн төвийн захирал Дийн Вокер, буцаж ирсэн номлогч Жэймс Рандаал зэрэг олон хүний тус дэмээр энэ ажил амжилттай үргэлжилсээр байна.

Монголын ард түмэнд оруулсан түүний зүтгэл, хувь нэмрийг өндрөөр үнэлж, Монголын Засгийн газраас Нөхөрлөлийн медалиар шагнасан байна. Түүний ариун үйлс улам дэлгэрэн дэвжих болтугай! ■

## Орон нутгийн захирал Ахлагч Нэй ба Систэр Нэй

Хүнсний ногоо тарих, гэрийн тэжээвэр амьтад өсгөн үржүүлэх  
2013 оны төсөл

Энэ жилийн төсөлд хот, хөдөөгийн бүх салбар, тойргуудын олон гэгээнтнүүд хамрагдан, Их Эзэний үлгэр жишээгээр жижигхэн үрийг тариалж, сайн үр жимс, арвин ургац хураан авч амьдрал ахуйгаа дээшлүүлэхийн зэрэгцээ бусдад тус дэм үзүүлжээ. Өнөр тойргийн Гантулга анх гурван галуу тэжээж эхэлсэн бөгөөд одоо 27 галуутай болоод байна. Галуунуудаа өсгөн үржүүлж тэжээх түүнийг хараад “Намайг дага” хэмээн хэлдэг “хоньчин” Аврагч Есүс Христийн жишээ надад санагдаж билээ. Шинэ Дархан салбарын 18 гэр бүл төмс, өргөст хэмх, лууван, сонгино, сармис тариалж, гэр бүлийнхээ хэрэгцээг бүрэн хангасан байна.

П.Хулан эгч энэ жил 2 төрлийн төмс, манжин, салатны навч, хулуу, улаан лооль тарьжээ. Баянзүрх салбарын олон гэр бүл, гишүүд энэ төсөлд хамрагдан, арвин ургац хураан авч өөрсдийн хэрэгцээг



Галуу тэжээх сайхан



Арвин ургац

хангасан байна. Наранчимэг эгчийнх ногооны том талбайтай бөгөөд тэднийх лууван, төмс, сармис, байцаа тариалахын зэрэгцээ галуу тэжээсэн

аж. Дашгэрэл эгчийнхэн мөн хүнсний ногоо тариалж туулай тэжээжээ. Тэднийх усжуулалтын системийг ашиглан ногоогоо усалдаг. ■



*Баянзүрх салбарын гишүүн Дашгэрэл эгч*



*Наранчимэг эгч талбай дээрээ*

## Гайхалтай үйлчлэл

Зүүнхараагийн Баян-Арцатын 9-р багийн Үйлчилгээний хэсэгт арав гаруй жил хуримтлагдсан хур хогийг Дээрэт Олон Улсын Энэрлийн байгууллага, багийн иргэд, олон нийтийн дэмжлэгтэйгээр цэвэрлэн, тээвэрлэж зайлуулсан тухай тус багийн засаг дарга Д.Хадбаатар мэдээллээ. Нийт 0,3 га орчим газрын 356 метр куб хогийг ачааны 6 машинаар зөөвөрлөж, 18 хүн сайн дураараа оролцсон бөгөөд уг хогийг цэвэрлэхэд нийт 12 цаг зарцуулжээ. ■



*Цэвэрлэсэн талбай*



*Хуримтлагдсан хур хог*



*Трактораар газрыг тэгшлэн цэвэрлэв*

## Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэргэнцэр хандивлав

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах "Бяцхан сувд" төв нь хүүхдүүдэд өөрийн хөдөлгөөн болон биеэ захирч сурахад нь туслах зорилгоор хүүхэд бүртэй нэг бүрчлэн ажилладаг. ДОУЭБ нь тус төвийн үйл ажиллагааг дэмжих, хүүхдүүдэд туслах зорилгоор тэргэнцэр болон хөдөлгөөнд туслах бусад хэрэгслүүд мөн хөргөгч гал тогооны тоног төхөөрөмжүүдийг хандивлалаа. Тус төвд өдөр бүр арав гаруй хүүхэд ирдэг бөгөөд итгэлтэй, хайр энэрлээр дүүрэн сүмийн гишүүдийн өгөөмөр



хандивын үрээр энэхүү хүмүүнлэгийн үйлс хэрэгжих боломжтой болдог билээ. ■

*ДОУЭБайгууллагынхан тус төвийн хүүхдүүдийн хамт*

## Сургалтын төвд хандив өргөв

Хорин жилийн турш үйл ажиллагаагаа Хявуулж буй "Амьдрах ухаан" сургалтын төвийнхөнд бид саяхан арван ширхэг оёдлын машин гардуулан өгөв. Тус төв нь гэр хорооллын залуучуудыг амьдрах ухаанд сургах, тэдэнд туслан дэмжих зорилгоор сургалт зохион байгуулдаг билээ.

Мөн ДОУЭБ нь тус төвийн мэргэжлийн тогооч бэлтгэх ангийн сургалтад зориулж гал тогооны тоног төхөөрөмж хандивлав. Залуучуудад мэргэжил эзэмшүүлэх мөн мэргэжлийн ур чадварыг нь дээшлүүлэх ажилд хамтран ажиллах болсондоо бид баяртай байна. ■